



АВЛИГЫН ХЭЛБЭРҮҮД

ХЭЭЛ ХАХУУЛЬ:

- Монгол хэлний их тайлбар толь бичигт **ХЭЭЛ ХАХУУЛЬ** гэдэг нь хувийн үйл хэргийг биелүүлэхийн тулд бусдад аргадан өгөх **эд юм, мөнгө төгрөг** гэж тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл, албан тушаал болон эрх мэдэлтэй хүнд бэлэн мөнгө, тодорхой үнэ шингэсэн хүний хэрэгцээ болон санаа сэтгэлийг дүүргэж чадахуйц тодорхой төрлийн **материаллаг эд зүйлс** өгч өөртөө ашигтай шийдвэр гаргуулах, үнэ төлбөргүй үйлчилгээнд хамрагдах, гэр бүл болон ойр дотнынхондоо хөнгөлөлт үзүүлэх зэрэг **эдийн бус** хэлбэртэй байдаг.

ШАН ХАРАМЖ:

- Албаны үүргээ зохих ёсоор биелүүлсний төлөө тухайн этгээдийг **хувиараа урамшуулан шагна**хыг хэлдэг. Жишээ нь, “ажил бүтээж өгсөнд баярлалаа” хэмээн аливаа хэлбэрээр бэлэг, санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэх мэт.

ХАНДИВ:

- Нийтийн албан тушаалтан буюу төрийн албан хаагчид тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр **санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх** болон **үйлчилгээ үзүүлэхийг** хэлнэ.

БЭЛЭГ:

- Нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй **эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх** болон **эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх**, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд **эрхээс татгалзах** зэрэг бусад хэлбэрийн **санхүүгийн үр ашгийг** хэлнэ.



ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС